



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/7/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Гэрээт аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775, khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |



Агуулга

| | |
|---|----|
| 1.Хараат бус аудиторын дүгнэлт..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 10 |
| 3. Аудитын тайлан..... | 11 |
| 3.1. Ерөнхий зүйл..... | 11 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй..... | 11 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт | 11 |
| 3.4. Материаллаг байдал | 12 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 12 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт | 13 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл..... | 13 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 14 |
| 3.9. Аудитын илрүүлэлт..... | 14 |
| Залруулсан алдаа..... | 14 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил | 14 |
| 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд | 15 |
| 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 15 |

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Аудит-02-24 № 156

танай _____ -ны № _____ -т

ХӨЛӨНБУЙР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ө.ШҮРЭНЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021281



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 55,738,284.40 | 34,533,805.94 |
| 33 | АВЛАГА | 158,400.00 | 624,015.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 158,400.00 | 624,015.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 55,579,884.40 | 33,909,790.94 |
| 354 | Хангамжийн материал | 41,664,884.40 | 22,429,790.94 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,009,480.00 | 5,026,609.94 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,817,194.40 | 10,791,151.00 |
| 35460 | Хүнсний материал | 10.00 | 2,808,830.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 3,838,200.00 | 3,803,200.00 |
| 35600 | Мал амьтад | 13,915,000.00 | 11,480,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,197,124,514.60 | 1,182,257,698.42 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,197,124,514.60 | 1,182,257,698.42 |
| 392 | Биет хөрөнгө | 1,155,991,014.36 | 1,141,351,698.42 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,087,291,062.70 | 1,125,023,725.70 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (65,198,455.80) | (100,173,920.38) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 88,264,651.70 | 93,035,114.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (61,563,610.19) | (72,519,254.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 67,808,171.33 | 72,632,447.33 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (42,536,435.35) | (45,644,588.51) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 114,835,120.00 | 114,835,120.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (38,939,417.03) | (51,866,873.31) |
| 39217 | Ном | 6,029,927.00 | 6,029,927.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 41,133,500.24 | 40,906,000.00 |
| 39301 | Програм хангамж | 700,000.00 | 700,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (472,499.76) | (700,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40,906,000.00 | 40,906,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II | 1,252,862,799.00 | 1,216,791,504.36 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 624,015.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 624,015.00 |
| 413 | Өглөг | - | 624,015.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 624,015.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 624,015.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,252,862,799.00 | 1,216,167,489.36 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,252,862,799.00 | 1,216,167,489.36 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 342,647,827.23 | 342,647,827.23 |
| 51101 | Өмч: - төрийн | 342,647,827.23 | 342,647,827.23 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 321,645,959.72 | 284,950,650.08 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 321,645,959.72 | 321,645,959.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (36,695,309.64) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 588,569,012.05 | 588,569,012.05 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V | 1,252,862,799.00 | 1,216,791,504.36 |



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------|------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 521,515,731.00 | 656,000,099.57 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 60,818,731.00 | 86,412,399.57 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 60,818,731.00 | 86,412,399.57 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 60,818,731.00 | 86,412,399.57 |
| 1200044 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ | 60,818,731.00 | 57,398,938.63 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ | - | 29,013,460.94 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 460,697,000.00 | 569,587,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 404,107,000.00 | 517,927,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 404,107,000.00 | 517,927,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,590,000.00 | 465,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 465,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 52,000,000.00 | 51,195,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 52,000,000.00 | 51,195,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 520,209,149.62 | 670,365,409.21 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 520,209,149.62 | 670,365,409.21 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 506,351,670.62 | 651,451,436.33 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 310,572,030.73 | 403,217,390.25 |
| 210101 | Үндсэн цалин | 310,572,030.73 | 403,217,390.25 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 40,813,132.27 | 51,199,183.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,996,685.86 | 34,978,236.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,232,601.80 | 4,115,086.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,557,921.45 | 3,228,229.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 638,720.29 | 807,057.33 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,387,202.87 | 8,070,573.28 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,200,000.00 | 48,714,248.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,569,267.00 | 5,226,399.87 |
| 210302 | Тулш, халаалт | 36,488,544.00 | 42,498,849.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,142,189.00 | 989,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,073,940.00 | 44,669,374.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,904,800.00 | 1,328,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,841,800.00 | 1,560,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,494,000.00 | 2,619,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 258,640.00 | 674,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 1,560,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,574,700.00 | 4,657,400.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 32,269,374.40 |
| 2105 | Нормативт зардал | 24,341,610.00 | 23,468,285.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 900,000.00 | 1,770,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,441,610.00 | 18,498,285.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 3,200,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,811,324.00 | 1,729,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,811,324.00 | 1,729,800.00 |
| 2107 | Томилголт, зочны зардал | 1,000,000.00 | 1,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилголт | 1,000,000.00 | 1,200,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 410,000.00 | 1,476,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 230,000.00 | 1,116,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 360,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,129,633.62 | 75,776,254.81 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,346,900.00 | 2,110,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 66,782,733.62 | 73,665,754.81 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,857,479.00 | 18,913,972.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,857,479.00 | 10,951,970.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,857,479.00 | 10,651,970.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 7,962,002.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,962,002.88 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,306,581.38 | (14,365,309.64) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 10,785,000.00 | 22,330,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 200,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 10,785,000.00 | 22,130,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (10,785,000.00) | (22,330,000.00) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (9,478,418.62) | (36,695,309.64) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 460,697,000.00 | 569,587,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 460,697,000.00 | 569,587,700.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 404,107,000.00 | 517,927,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 404,107,000.00 | 517,927,500.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,590,000.00 | 465,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 465,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 52,000,000.00 | 51,195,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 52,000,000.00 | 51,195,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 457,627,000.00 | 569,587,700.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 457,627,000.00 | 569,587,700.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 443,325,800.00 | 551,914,722.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 313,100,800.00 | 403,785,073.25 |
| 210101 | Үндсэн цалин | 238,493,000.00 | 267,692,489.94 |
| 210102 | Нэмэгдэл | 37,294,800.00 | 101,400,934.36 |
| 210104 | Урамшуулал | 37,313,000.00 | 34,691,648.95 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,137,600.00 | 50,473,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,690,100.00 | 34,321,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,111,700.00 | 4,037,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,489,800.00 | 3,230,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 622,600.00 | 807,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,223,400.00 | 8,075,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 44,700,000.00 | 48,714,248.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,069,267.00 | 5,226,399.87 |
| 210302 | Түлш, халаалт | 36,488,544.00 | 42,498,849.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,142,189.00 | 989,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,687,740.00 | 13,021,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,850,000.00 | 1,800,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,391,800.00 | 1,560,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,494,000.00 | 2,619,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 219,040.00 | 665,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн үстгал, ариутгал | - | 1,560,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,732,900.00 | 4,817,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 24,543,800.00 | 28,718,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 900,000.00 | 2,970,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,381,800.00 | 22,548,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,262,000.00 | 3,200,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,890,960.00 | 2,479,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,890,960.00 | 2,479,800.00 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 1,000,000.00 | 1,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 1,000,000.00 | 1,200,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 410,000.00 | 1,476,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 230,000.00 | 1,116,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 360,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,854,900.00 | 2,046,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,854,900.00 | 1,796,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 14,301,200.00 | 17,672,977.88 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 14,300,631.00 | 9,710,975.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,300,631.00 | 9,410,975.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 300,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 569.00 | 7,962,002.88 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 569.00 | 7,962,002.88 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| C01 | 2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 342,647,827.23 | 588,569,012.05 | 321,645,959.72 | 0.00 | 1,252,862,799.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 342,647,827.23 | 588,569,012.05 | 321,645,959.72 | 0.00 | 1,252,862,799.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 342,647,827.23 | 588,569,012.05 | 321,645,959.72 | 0.00 | 1,252,862,799.00 |
| D01 | 2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 342,647,827.23 | 588,569,012.05 | 321,645,959.72 | 0.00 | 1,252,862,799.00 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 342,647,827.23 | 588,569,012.05 | 321,645,959.72 | 0.00 | 1,252,862,799.00 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -36,695,309.64 | 0.00 | -36,695,309.64 |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 342,647,827.23 | 588,569,012.05 | 284,950,650.08 | 0.00 | 1,216,167,489.36 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 569,122,700.00 | 561,160,697.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 569,122,700.00 | 561,160,697.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 557,317,800.00 | 551,749,722.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 403,785,200.00 | 403,785,073.25 |
| 210101 | Үндсэн цалин | 267,692,500.00 | 267,692,489.94 |
| 210102 | Нэмэгдэл | 101,401,000.00 | 101,400,934.36 |
| 210104 | Урамшуулал | 34,691,700.00 | 34,691,648.95 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,473,100.00 | 50,473,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,321,700.00 | 34,321,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,230,300.00 | 4,037,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 807,600.00 | 3,230,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,037,800.00 | 807,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,075,700.00 | 8,075,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 48,715,400.00 | 48,714,248.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,226,400.00 | 5,226,399.87 |
| 210302 | Түлш, халаалт | 42,500,000.00 | 42,498,849.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 989,000.00 | 989,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,856,500.00 | 12,856,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,560,000.00 | 1,560,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,619,500.00 | 2,619,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,560,000.00 | 1,560,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,817,000.00 | 4,817,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,252,200.00 | 28,718,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,970,000.00 | 2,970,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 28,082,200.00 | 22,548,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,200,000.00 | 3,200,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,479,800.00 | 2,479,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,479,800.00 | 2,479,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,509,600.00 | 1,476,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,149,600.00 | 1,116,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 360,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,046,000.00 | 2,046,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,000.00 | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,796,000.00 | 1,796,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11,804,900.00 | 9,410,975.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,804,900.00 | 9,410,975.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,804,900.00 | 9,410,975.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 569,122,700.00 | 561,160,697.12 |
| 1310 | ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 569,122,700.00 | 561,160,697.12 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих | 517,927,500.00 | 509,965,497.12 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 51,195,200.00 | 51,195,200.00 |



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|---|-------------|-------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 0.00 | 465,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 0.00 | 465,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 0.00 | 165,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.00 | 165,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 165,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 300,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 300,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 300,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | |

3.Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ө.Шүрэнчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 01-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 04 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих
- Монгол Улсын Боловсролын тухай хууль, төрийн холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 670,365.4 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 13,408.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,071.3 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 158.4 | 624.0 | 465.6 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 55,579.8 | 33,909.7 | -21,670.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,197,124.5 | 1,182,257.7 | -14,866.8 |
| Нийт хөрөнгө | 1,252,862.7 | 1,216,791.4 | -36,071.3 |
| Өр төлбөр | | 624.0 | 624.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,252,862.7 | 1,216,167.4 | -36,695.3 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,252,862.7 | 1,216,791.4 | -36,071.3 |

Авлага, өглөгийн данс 624.0 мянган төгрөг байгаа нь Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчаас хувь хүний орлогын албан татвар суутгаснаас үүссэн.

Бараа материал данс 33,909.7 мянган төгрөг болж, 21,670.1 мянган төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй шилжүүлсэн бараа материалаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 1,182.257.7 мянган төгрөг болж 14,866.8 мянган төгрөгөөр буурсан байна. Хөрөнгө оруулалтаар 57,398.9 мянган төгрөг, төсвийн худалдан авалтаар 1,600.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Акталсан үндсэн хөрөнгө 11,671.5 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо данс 36,695.3 мянган төгрөгөөр өөрчлөгдсөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 134,484.4 мянган төгрөгөөр буюу 25.7 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 150,156.2 мянган төгрөгөөр буюу 28.8 хувиар өссөн байна. Үнэ төлбөргүй гарсан бараа материалын зарлагатай холбоотой байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 583,172.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 583,172.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 14,049.7 мянган төгрөгөөр бууруулж 569,122.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 569,122.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 517,927.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 51,195.2 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 517,927.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 51,195.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 569,122.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 561,160.7 мянган төгрөгийг зарцуулж 7,962.0 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 561,160.7 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь үдийн цай болон хоолны 7,962.0 мянган төгрөгийг дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал гарснаас үүдэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 465.0 мянган төгрөгийн дэмжлэг авч, ном хэвлэлд 165.0 мянган төгрөг, шагнал, урамшуулалд 300.0 мянган төгрөг зарцуулсан байна.

3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 129, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22 гүйлгээний 36,571.5 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,325.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 112,362.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг 100 хувьтай биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|-----------|---------|-----------|-------|-----|-------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,325.0 | 1 | 1,325.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Албан шаардлага | 3 | 112,362.7 | 3 | 112,362.7 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Нийт дүн | 4 | 113,687.7 | 4 | 113,687.7 | 0.0 | 0.0 | 100.0 |

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 151,736.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 151,112.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 624.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайлан тусгаж, баталгаажууллаа. Үүнд:

Малын данснаас хасалтын бичилт 13,780.0 мянган төгрөгийг орлогын дансанд бичсэнийг залруулсан.

Харилцахаас нэмэгдэл цалин, урамшууллаас гарсан 136,091.6 мянган төгрөгийн гүйлгээг үндсэн цалин дансанд тохируулах бичилтээр хаасныг залруулсан.

Хүүхдийн хоол, үдийн цайны зардал 1,241.1 мянган төгрөгөөр хүнсний тайланд зөрүүтэй тусгасныг залруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос нийт 624.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган авсныг авлага, өглөг үүсгэж залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Хөгжлийн бэрхшээлтэй, групптэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 624.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос нийт 624.0 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх "дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.2 дахь "хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..." гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.



3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган тооцсон байна. Үүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|--|--|--------------------|
| Огноо: | Аудитын нэр: | Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
| 2020 | | | ДОА-2021/7/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургууль | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|------------|---|--------------|---------------------------------------|---|------------------------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6 мэдээллийн 18,693.0 мянган төгрөгийн гүйлгээг байршуулаагүй | | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Ө.Шүрэнчимэг Б.Тананцэцэг |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан. | 624.0 | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Ө.Шүрэнчимэг Б.Тананцэцэг |
| ДҮН | | 624.0 | | | |